

ШИНЖЛЭХ УХААН,
СОЁЛ

«МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ»
ГАРЧИГИЙН УЧИР

А. ЛУВСАНДЭНДЭВ
ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Монголын ард түмний үндэсний соёлын бахархал, манай утга зохиолын суут бүтээл «Монголын Нууц Товчоог» Оросын алдарт эрдэмтэн Палладий Кафаров 1866 онд нээж, шинжлэх ухааны эргэлтэд оруулснаас хойш 120 жил болж байна. Энэ завсар «Монголын Нууц Товчоог» Орос Зөвлөлтийн эрдэмтэн С. А. Козин, Германы Э. Хейниш, Францын П. Пельо, Унгарын А. Лигети, Хятадын Е. Төхүзи, Бельгийн А. Мостэрт, Японы Ш. Озава, Америкийн Ф. В. Кливз, Австралийн И. Рахевильтр, Монголын Ц. Дамдинсүрэн нарын зэрэг эрдэмтэн судалж, орос хятад, япон, франц, герман, унгар, польш зэрэг хэлэнд орчуулж, дэлхий дахины олон уншигчдад танилцуулжээ.

«Монголын Нууц Товчоог» судлагч эрдэмтэн, утга зохиол судлагчид «тал нутгийн үнэр анхилуулсан» энэ гайхамшигт зохиолыг Оросын «Игорийн цэргийн тууж», Францын «Роландын дуулал», Грекийн «Илиада», «Одиссея», Гүржийн «Барын арьсан хэвнэгт баатар» зэрэг алдарт зохиолуудтай эн зэрэгцэх бүтээл гэж хүндэтгэн үзсээр ирсэн билээ.

Монголын ард түмний өвөрмөц амьдралыг тусгасан, түүний хүсэл эрмэлзлийн илрэл болсон «Монголын Нууц Товчоо» бол дэлхийн соёлын эрдэнэсийн санд манай ард түмний оруулсан үлэмжийн хувь нэмэр юм.

Нарт ертөнцөд хүн төрөлхтөний соёлыг ганц боловч хүн сонирхож байсан цагт «Монголын Нууц Товчоо» мөнхжин орших болно.

«Монголын Нууц Товчоог» 1240 онд зохиосон бөгөөд ирэх 1990 онд 750 жилийн нь ой болно. Энэ ойг угтан манай орны хэл зохиол судлагчид «Монголын Нууц Товчооны» тухай судалгаа хийж жинхэнэ эхийг нь хэвлэхээс гадна олон түмэнд сурталчлах ажлыг өргөн хийх болно.

«Монголын Нууц Товчоо» бол «Игорийн цэргийн тууж» мэтийн буурал эртний үед зохиосон бусад агуу их бүтээлүүдийн нэгэн адил судлах тутам шийдвэрлэхийг шаардсан шинэ шинэ асуудлыг бидний өмнө гарган тавьсаар байна.

«Монголын Нууц Товчоо» Cinggis qahan-nu huj'a'ur de'ere tenggeri-eče jaya'atu türeksen Börte-čino aju'u гэсэн үгээр эхэлдэг билээ.¹ Монголын судлалын ууган төв, «Монголын Нууц Товчооны» тухай шинжлэх ухааны эх үүсвэрийг тавьж хөгжүүлсэн Орос, Зөвлөлтийн эрдэмтэд, тухайлбал, Монголын Нууц Товчоог» олон жил шамдан судлаж, гурван боть эрдэм шинжилгээний ганц сэдэвт зохиол туурвисан акад.

1. С. А. Козин, Сокровенное сказание монголов, М-Л, 1941. с. 79 Histoire Secrète des Mongols. Par Paul Pelliot. Paris 1949, p. 5 A Mongolok titkos története, közzéteszi Ligeti Layos, Budapest, 1964, p. 15 Pieces de shancellerie en transcription shinoise Par Louis Ligeti, Monumenta Linguae Mongolicae Collecta, 111, Budapest, 1972 «Монголын Нууц Товчоо, галиглаж хэвлүүлсэн. Т. Дашцэдэн. редактор Ц. Дамдинсүрэн, Н. Ишжамц, Corpus Scriptorum Mongolorum, Том. XXI, Fasc. I. Ulan-Bator, 1985. 10 Баяр. Mongol-un niyuca tobciyan, terigün debter. Obür mongyol-un arad-un keblel-ün Xoriy-a, 1981. I.

С. А. Козин өмнө иш татсан хэсгийг нэгэн өгүүлбэр гэж үзээд, «Предком Чингис-хана был Борте-Чино, родившийся по изволнению Вышнего Неба» (Козин, дурдсан зохиолд) («Чингис хааны язгуур Дээд Тэнгэрээс заяат төрсөн Бөрте-Чоно ажгуу») гэж орчуулжээ.

Францын алдарт эрдэмтэн П. Пельо «Монголын Нууц Товчооны» Эхийн дээр иш татсан хэсгийг *L'origine de Cinggis-qahan est Börte Cino ("le Loup..., /venu/ naïtre, du Ciel qui est en haut, par mandat (céleste);* (дурдсан зохиолд) ... («Чингис хааны язгуур нь дээр орших Тэнгэрийн тааллаар төрсөн Бөрте-Чоно билээ») гэж Франц хэлэнд орчуулжээ.

Мөнхүү хэсгийг манай орны нэрт монголч эрдэмтэн Ц. Дамдинсүрэн орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлсэн нь: «Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртечино»².

Австралийн эрдэмтэн И. Рахевильтр иш татан бүхий хэсгийг англи хэлэнд: *The origins of Chinggis-qahan. There was once a bluish wolf who was born with his destiny preordained by Heaven Above* («Чингис хааны гарал. (Урьд) нэг цагт Дээд Тэнгэрээс заяат төрсөн хөхөмдөг чоно байжээ»)³ гэж *Cinggis qahan-nu huja'ir* гэснийг уг зохиолын гарчиг гэж үзсэн Б. И. Панкратовын саналыг⁴ баримтлан урьдын эрдэмтдээс өөрөөр ойлгож орчуулсан байна.

Cinggis qahan-nu huja'ur гэсэн үгийг «Монголын Нууц Товчооны» жинхэнэ нэр гэж эдгээр хүндэт эрдэмтдийн үзсэний үндэс нь юу байна?

«Монголын Нууц Товчооны» хятад утга үсгээр галиглаж, хятад утгачилсан орчуулга, мөр мөрөөр үгчилсэн орчуулга хавсаргасан эхийн эхний хуудасны эхний мөр юань-чао би ши гэсэн хятад гарчгаар эхлэж, түүний доор *Mongyol-un niqıca tobciyan* гэж монгол гарчгийг нь тавьсныг юуны өмнө дурдаж, энэ бол гарчгийг хожим хятад түшмэд тавьсны гэрч, хэрэв *Mongyol-un niqıca tabciyan* гэдэг үг анхнаасаа уул зохиолын гарчиг байсан бол Юань-чао би-ши гэсэн хятад гарчгаар эхлэхгүй, монгол гарчгаар нь эхэлж, хятад гарчгийг нь доор нь тавих ёстой байсан гэж тэдгээр эрдэмтэд үзэж байна. (Панкратов мөн зохиолд). Бидний бодоход энэ нь төдий л ноцтой баталгаа болж чадахгүй юм.

«Монголын Нууц Товчооны» хятад утга үсгээр галиглаж, хятад утгачилсан орчуулга, мөр мөрөөр үгчилсэн орчуулга хавсаргасан эхийг хятад хүнд зориулан боловсруулсан нь ямар ч эргэлзээгүй билээ. Учир иймээс хятад гарчгаар уг зохиолыг эхэлсэнд гайхах зүйл алга гэж бодно.

Цаашилбал *Cinggis qahan-nu huja'ur* гэдэг үгийг «Монголын нууц Товчооны» эхэд бүтэн мөр эзлүүлэн ард нь 10—12 хятад үсэг бичиж болохоор зай үлдээж бичсэнийг гарчиг болохын гол нотолгоо болгож байна (Панкратов. Мөн зохиолд). Энд дундад үеийн монгол бичигт хааны нэрийг тэтгэж бичдэг байсныг гарчиглахтай хутгаж байна. «Чингисийн чулууны бичигт» Чингис хаан гэсэн хоёр үгийг тэтгэж эхний мөрийг эзлүүлсэн байдаг. Ил хаадын бичгийн эхэнд хаадын нэрсийг тус бүр бүтэн мөр эзлүүлэн бичсэн буй. 1314 онд тунхагласан Буянт хааны зарлигт:

2. Ц. Дамдинсүрэн. Монголын Нууц Товчоо (Эртний монгол хэлнээс орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлсэн) УБ. 1972., 19-р тал.

3. *The Secret History of the Mongols, Chapter I, by Jgor de Fachewiltz (Transl). In The Mongolia Society Bulletin, Vol. IX №. 1, Spring. 1970. p. 56,*

4. Юань-ча) би-ши (Секретная история Монголов), 15 цзюаней, Том. Издание текста и предисловие Б. И. Панкратова. М., 1962. с. 9 — 10

«Чингис хааны
Өгээдэй хааны
Цэцэн хааны
Өлзийт хааны
Хүлэг хааны ба зарлигт»

гэж хаадын нэрийг тэтгэсэн байна.

«Чингис хааны язгуур» гэсэн нь уг зохиолын гарчиг биш гэдгийн хөдлөшгүй баттай баримт бол «Монголын Нууц Товчооны» хэл байна.

И. Рахевилтц "De'ere tenggeri-eče jaya'atu türeksen Börte čino aju'u гэдгийг бүтэн бүрэлдэхүүнтэй нэг өгүүлбэр гэж үзжээ. Гэтэл уг өгүүлбэрийг бүтцийн талаас нь авч үзвэл өгүүлэгдэхүүн байхгүй, хагас бүрэлдэхүүнт өгүүлбэр, зөвхөн өгүүлэхүүний хэсэг байна. Börte-čino aju'u гэж өгүүлэхүүн de'ere tenggeri-eče jaya'atu türeksen гэж тодотгол гишүүн өгүүлбэр, өгүүлэгдэхүүн байхгүй байна.

Үүнтэй холбогдуулан «Монголын Нууц Товчооны» хоёрдахь өгүүлбэрийг аваад үзье. Gergei inu Qo'ai-Maral aji'ai гэдгийн Qo'ai-Maral aji'ai гэдэг нь өгүүлэхүүн gergei inu гэдэг нь өгүүлэгдэхүүн болно. Эхний өгүүлбэр энэ мэтчилэн өгүүлэгдэхүүнтэй байх ёстой. Өмнө нь өгүүлбэр байсан, түүнээс юуны тухай өгүүлж байгаа нь тодорхой байсан ахул өгүүлэгдэхүүн байхгүй байж болох билээ. Үүнийг ч И. Рахевилтц зөн бэлгээр ойлгон англи орчуулгадаа «Монголын Нууц Товчооны» эхэд байхгүй (урьд) нэг цагт (once) гэсэн үгийг нэмжээ... Энэ үгийг нэмснээр зохиолын найруулга огт өөр болж, түүхэн ойллого бичгийн найруулгаа алдаж, ардын аман зохиол, үлгэрийн эхэнд хэлдэг үгийн найруулгатай болж байна. Монгол ардын үлгэр бүхэн «Урьд нэг цагт (өвгөн эмгэн байжээ)», гэж эхэлдгийг монгол ардын аман зохиолтой өчүүхэн төдий боловч танилцсан хүн бүхэн мэднэ. Монгол ардын үлгэрийн ямарваа эмхтгэлийг аваад үзэхэд миний хэлсэн үг нотлогдоно.

De'ere tenggeri-eče jaya'afu törelksein Börte-čino aju'u гэж бичихээр бичгийн зохиолын ч эхлэл биш, аман зохиолын ч эхлэл биш болж байна. Аман зохиолын эхлэх бол: uridu nige čaptu börte čino aju'u гэсэн байх ёстой. Галиглахдаа ингэж börte гэдгийг бага үсгээр эхэлж, börte, čino гэсэн хоёр үгийн хооронд богино зураас тавихгүй байх ёстой. Börte гэдгийг том үсгээр эхлэж бичээд дурдсан хоёр үгийн хооронд богино зураас тавина гэдэг оноосон нэр болгоно гэсэн үг бөгөөд ямар нэгэн чонын тухай өгүүлж байгаа биш, Börte-čino гэдэг нэртэй хүний тухай өгүүлж буй хэрэг болно. «Монголын Нууц Товчооны» зохиогчдын санаагаар бол уг зохиолд ерийн нэг чонын тухай байтугай, овгийн сүлд тэнгэрийн тухай ч өгүүлж байгаа биш, овгийн ойд хадагдан хадгалагдаж байгаа өвөг дээдэс, Чингис хааны өвөг дээдэс, түүхт хүмүүсийн нэрсийн жагсаалтын эхний хүний нэрийг дурдаж байна. Ийм овгийн өвөг болсон хүмүүсийн нэрс «Монголын Нууц Товчоонд» олон гарч байна. Гагцхүү Чингисийн овгийн дээд өвөг тэнгэрээс заяатай байна. Бид хойт үеийн хүмүүс Бөртэ-чоно гэдгийг домог гэж үзнэ үү, түүхт хүн гэж үзнэ үү, энэ бол жич асуудал юм. Монголын Нууц Товчооны зохиогчид бол Бөртэ чоныг түүхт хүн, тэнгэрээс заяатай хүн, тийм учраас удам угсаагийг нь залгамжилсан Чингис хаан жирийн хүн биш, тэнгэрээс заяатай хүн, жирийн хүмүүсийг байтугай, хамгийн эртний сурвалжит гэрийн тэргүүний хувьд бусад сурвалжтаныг ноёлох ёстой гэдэг улс төрийн үзлийг нотлох зорилготой, энэ зорилгодоо монгол хэлийг ашиглах бүрэн чадвартай хүмүүс байлаа. Тэдний бичсэн зүйл бидний санаанд нийлнэ үү, үгүй юу, бид байгаагаар нь ойлгохыг оролдох ёстой, өөрсдийн ойлголтод нийцүүлэн эх бичгийг өөрчлөх эрх бидэнд байхгүй.

Хятад утгын орчуулга хийсэн хүн бидний сонирхон бүхий «Монголын Нууц Товчооны» эхлэлийг

(«Угтаа Юан улсын дээд өвөг нь тэнгэр язгуурт нэгэн зүйл хөхөмдөг зүсмийн чоно байжээ») гэж хөрвүүлжээ. «Монголын Нууц Товчоог» зохиосны дараахан XIV зууны үед монгол хэлнээс хятад хэлэнд хөрвүүлсэн энэ орчуулгад уг эхлэлийг нэгэн өүүлбэр болгосон явдал маш чухал баримт гэж бид үзнэ. Тэр үеийн Хятадын хааны ордны хэлмэрч тухайн үеийн монгол хэлийг сайн мэдэхгүй, номын гарчгийг эхээс нь ялгаж чадахгүй, ийм том зохиолыг орчуулж байсан гэхэд сэтгэлд нэг л багтахгүй байна. Мин улсын үеэс бидний гар дээр хүрч ирсэн Хятадын хааны монгол хэлээр бичсэн бичиг захидлыг үзэхэд тэр үеийн хэлмэрч түшмэд монгол хэлийг нэвтэрхий сайн мэдэж байсан нь илэрхий байдаг.⁵

Тэдний дундаас мэдлэг муутай нь «Монголын Нууц Товчоог» орчуулах албанд тохоогдсон байж таарамгүй юм. Орчуулгын найруулга нь ч үүнийг давхар гэрчилж байна. Эхлэлийг бүр зориуд (угтаа, нэгэн зүйл, зүсмийн гэсэн үг нэмэн үлгэрийн эхлэлийн байдалтай болгосон нь Чингис хааныг тэнгэрээс заяат дээд өвөгтэй байсан гэсэн нь үнэндээ хоосон домог юм гэдгийг нарийн аргаар илчлэх гэсэн хэрэг байж ч болох юм. Тэдэнд Чингисийн угсааныхны нөлөөг дээшлүүлэх зорилго байгаагүй нь лавтай буй за. Юу боловч «Монголын Нууц Товчоог» хятад хэлэнд орчуулж, бидэнд эрдэм шинжилгээний чухал хэрэглэгдэхүүн үлдээсэн хэлмэрч түшмэл монгол хэлийг төгөлдөр мэдэж байсан нь маргаангүй буй за.

Цаашилбал, орчин цагийн монгол хэлэнд хуучирсан үгийн байдалтай явцуу хэрэглэгдэж байсан а- гэдэг үйл үгэнд мэдэгдэж өнгөрсөн цагийн ju'u дагаврыг хэрэглэсэн нь санамсаргүй хэрэг биш байна. Чухам энэхүү үйл үг «Монголын Нууц Товчооны» нэгдүгээр бүлэгт 12 удаа хэрэг хэрэглэхдээ цөмд нь нийлмэл өгүүлэхүүний бүрэлдэхүүнд орж байна. Энэ нь Börte-Cino aju'u гэдэг нийлмэл өгүүлэхүүн болохын давхар нотолгоо болох буй за.

5. Ligeti, Monumenta Linguae Mongolicae Collecta, III, Budapest, 1972.